

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2024 он	Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: baasanjargalq@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	12
5.1 Төлбөрийн акт	12
5.2 Албан шаардлага	12
5.3 Зөвлөмж.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.03.14 № 128
танай _____ -ны № _____ -т

Б А Р У У Н БҮСИЙН ТАМИРЧДЫГ
ОЛИМПД БЭЛТГЭХ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Г.ТҮВШИНБАТ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв нь тайлант онд 32.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад дүгнэлт өгөх санхүүгийн аудитаар тайлант онд 26.7 сая төгрөгийн татвар, халаалт болон түрээсийн орлогын өглөг үүсгэсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.8 сая төгрөг, зарлагын 33.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах шийдвэр, гэрээ зэргийг тухай бүр шилэн дансны цахим мэдээллийн системд мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв ОНӨААТҮГ нь 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 33.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 20.2 сая төгрөгийн тавилга эд хогшил шилжиж ирсэн байна.

Audit(D)2023CTA/A4-toot

013020394

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41517739.45	47757937.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3914045.46	8606135.26
312	Банканд байгаа бэлэн мөнгө	3,914,045.46	8,606,135.26
33	АВЛАГА	5,187,499.99	5,329,108.54
33401	Дансны авлага /ТӨҮГ/	5,187,499.99	5,329,108.54
35	БАРАА МАТЕРИАЛ	32416194.00	33822694.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	32,236,194.00	33,642,694.00
354	Хангамжийн материал	180000.00	180000.00
35410	Бичиг хэргийн материал	180,000.00	180,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	155167666.51	132813784.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	155167666.51	132813784.35
391	Хашаа	211,332,368.00	211,332,368.00
392	Биет хөрөнгө	-54679701.49	-77033583.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,485,000.00	1,485,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,966,328.80	-95,099,565.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,226,666.67	39,223,566.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,594,666.21	-37,437,483.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,169,626.86	35,478,521.86
39208	Хуримтлагдсан элэгдэл		-20683623.24
393	Биет бус хөрөнгө	-1485000.00	-1485000.00
39301	Программ хангамж	0.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,485,000.00	-1,485,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196685405.96	180571722.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5134395.49	26713039.61
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5134395.49	26713039.61
413	Өглөг	5134395.49	26713039.61
4136	Бусад өглөг	5134395.49	26713039.61
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		6,070,037.72
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	5,134,395.49	20,643,001.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	186347298.22	153858682.54
51	Засгийн газрын хувь оролцоо	186347298.22	153858682.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	172874000.00	172874000.00
51101	Өмч: - төрийн	22,874,000.00	22,874,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	150,000,000.00	150,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	13473298.22	-19015317.46
51210	Өмнөх үеийн үр дүн	13,473,298.22	13,473,298.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-32,488,615.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	191481693.71	180,571,722.15

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	762849961.00	828806350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	762849961.00	828806350.00
120	Нийтлэг татварын бус орлого	762849961.00	828806350.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	748835711.00	807087950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	748,835,711.00	807,087,950.00
120005	Түрээсийн орлого	14,014,250.00	21,718,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	773951735.56	861294965.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773951735.56	861294965.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773951735.56	861294965.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	37068556.54
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	37,068,556.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	452785721.81
210301	Гэрэл, цахилгаан	00.00	29,087,890.21
210302	Түлш, халаалт	00.00	23,702,030.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	392,436,830.00
210304	Байрны түрээс	00.00	7,558,971.60
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2911100.00
210401	Бичиг хэрэг	00.00	1,013,650.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	158,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	1,739,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	3055500.00
210604	Урсгал засвар	00.00	3,055,500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	2529400.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,529,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	773951735.56	330931620.38
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	117,150.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	773,951,735.56	330,814,470.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	32013066.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,940,429.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	24,922,637.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11101774.56	-32488615.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-11101774.56	-32488615.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	768143795.00	829046670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102824995.00	111062370.00
120	Нийтлэг татварын бус орлого	102824995.00	111062370.00
120009	Бусад орлого	1,600,000.00	340,320.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	101,211,411.00	110,722,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	665318800.00	717984300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	665318800.00	717984300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	665,318,800.00	717,984,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	759842909.15	816474535.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759842909.15	816474535.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759842909.15	816474535.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183243858.55	238002303.60
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	183,243,858.55	238,002,303.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53668793.77	70395341.25
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	53,668,793.77	70,395,341.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445890479.44	428394450.21
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	445,890,479.44	428,394,450.21
2104	Хангамж, бараа материалын зардал	37057739.00	43558359.75
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	37,057,739.00	43,558,359.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39982038.39	36124080.39
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	16,999,180.39	14,313,630.39
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	22,982,858.00	21,810,450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8300885.85	12572134.80
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4551900.00	1160250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4551900.00	1160250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4551900.00	1160250.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	4,551,900.00	1,160,250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4551900.00	-1160250.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	6719795.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	00.00	00.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	00.00	6,719,795.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	-6719795.00

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3748985.85	4692089.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	165,059.61	3,914,045.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,914,045.46	8,606,135.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин			-11,101,774.56		-11,101,774.56
C07	Тайланг үеийн үр дүн	22,874,000.00	00.00	24,575,072.78	150,000,000.00	197,449,072.78
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,874,000.00	0.00	13,473,298.22	150,000,000.00	186,347,298.22
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,874,000.00	0.00	13,473,298.22	150,000,000.00	186,347,298.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,874,000.00	0.00	13,473,298.22	150,000,000.00	186,347,298.22
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-32,488,615.68	00.00	-32,488,615.68
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,874,000.00	0.00	-19,015,317.46	150,000,000.00	153,858,682.54

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Хэтрэлт, Хэмнэлт
Орлого				
1	Татаас/төсвийн орлого/	717,984,300.0	717,984,300.0	
2	Өөрийн орлого	97,440,000.0	110,822,050.0	13,382,050.0
2.1	Үйлчилгээний орлого	60,000,000.0	63,795,350.0	3,795,350.0
2.2	Түрээсийн орлого	19,440,000.0	21,718,400.0	2,278,400.0
2.3	Бусад үйлчилгээний орлого	18,000,000.0	25,308,300.0	7,308,300.0
	Дүн	815,424,300.0	828,806,350.0	
Зарлага				
1	Цалингийн зардал	292,000,000.0	291,185,080.6	(814,919.4)
2	НДШ	37,245,200.0	37,068,556.5	(176,643.5)
3	Ашиглалтын зардал	441,234,400.0	445,226,750.2	3,992,350.2

3.1	Дулааны эрчим хүч	391,434,400.0	391,434,400.0	-
3.2	Цахилгаан эрчим хүч	25,000,000.0	29,087,890.2	4,087,890.2
3.3	Цэвэр.бохир ус	24,800,000.0	24,704,460.0	(95,540.0)
4	Норматив зардал	19,504,000.0	19,693,639.8	189,639.8
4.1	Түүхий эд материал	11,800,000.0	11,610,639.8	(189,360.3)
4.3	Цэвэрлэгээ үйлчилгээ	7,704,000.0	8,083,000.0	379,000.0
5	Хангамж	6,780,000.0	6,818,650.0	38,650.0
5.1	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуй	600,000.0	825,000.0	225,000.0
5.2	Галын аюулгүй байдал	4,980,000.0	4,980,000.0	-
5.3	Бичиг хэргийн зардал	1,200,000.0	1,013,650.0	(186,350.0)
6	Эд хогшил, урсгал засварын зардал	14,900,000.0	18,154,400.0	3,254,400.0
6.1	Засвар (гадна талбай тохижилт)	5,500,000.0	4,500,000.0	(1,000,000.0)
6.2	Эд хогшил (үйлчлүүлэгчдийн хэс)	9,400,000.0	13,654,400.0	4,254,400.0
7	Нийгмийн баталгаа зардал	1,200,000.0	843,400.0	(356,600.0)
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4,178,400.0	3,939,600.0	(238,800.0)
8.1	Интернэт, засвар үйлчилгээ	1,800,000.0	1,800,000.0	-
8.2	Суурин утасны зардал	158,400.0	158,400.0	-
8.3	Усны шинжилгээ, ариутгал төлбөр	1,800,000.0	1,739,050.0	(60,950.0)
8.4	Ажилчдын эмчийн үзлэг	300,000.0	125,000.0	(175,000.0)
8.6	Банкны үйлчилгээ	120,000.0	117,150.0	(2,850.0)
9	Томилолт, тэмцээн, уралдааны зардал	8,700,000.0	5,992,850.0	(2,707,150.0)
10	Бусад зардал	100,000.0	7,449,401.1	7,349,401.1
	Нийт дүн	825,842,000.0	836,372,328.2	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ нь нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, аймгийн хэмжээнд усан спортыг хөгжүүлэх, сургалт, хүмүүжлийн үйлчилгээ, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийг аймгийн ИТХ-ын даргын 2022 оны А/44 захирамжаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын үйл ажиллагаандаа дараах хуулийг дагаж мөрддөг байна. Үүнд - Биеийн тамир, спортын тухай хууль - Нийгмийн даатгалын тухай хууль - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль -Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль -Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - Хувь хүний орлогын албан татварын тухай хууль -Хөдөлмөрийн тухай хууль -Шилэн дансны тухай хууль -Бусад хууль Тайлант хугацаанд “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, НББОУС, СТОУС-д нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,271.7 төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,914.0	8,606.1	4,692.1
Авлага	5,187.5	5,329.1	141.6
Бараа материал	32,416.2	33,822.7	1,406.5
Үндсэн хөрөнгө	150,325.7	132,813.8	(17,511.9)
Нийт хөрөнгө	191,843.4	180,571.7	(11,271.7)
Өр төлбөр	5,496.1	26,713.0	21,216.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	186,347.3	153,858.7	(32,488.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	191,843.4	180,571.7	(11,271.7)

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгийн дүн 11,271.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 21,216.9 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын зардал болон ажиллагсадтай холбоотой татварын өр, түрээсийн орлого төвлөрүүлэх өр зэргээс үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 32,488.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд алдагдалтай ажилласантай холбоотой байна

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны орлого, зарлагын саналд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрийн орлогоос 97,440.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 717,984.3 мянган төгрөг, үйлчилгээний орлого 60,000.0 мянган төгрөг, түрээсийн орлого 19,440.0 мянган төгрөг, бусад орлогыг 18.0 сая төгрөгөөр нийт зарлагыг 815,424.3 мянган төгрөгөөр тооцон баталсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр 828,806.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 836,372.3 мянган төгрөгийн зардал гарган 7.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогыг гүйцэтгэл 815,424.3 мянган төгрөг төлөвлөснөөс 828,806.3 мянган төгрөг буюу 1.6 хувиар өссөн нь өөрийн үйл ажиллагааны орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 825,842.0 мянган төгрөг төлөвлөснөөс 836,372.3 мянган төгрөг буюу 1.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь ашиглалтын зардал, эд хогшил, урсгал засварын зардал өссөнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, явцын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийг нийт зарлага 613,736.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,206.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,904.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлаг 861,294.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,919.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,689.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.8 сая төгрөг, зарлагын 33.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах шийдвэр, гэрээ зэргийг тухай бүр шилэн дансны цахим мэдээллийн системд мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 19,773.5 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	
Албан шаардлага	-	-	-	-	
Зөвлөмж	2	19,773.5	2	19,773.5	
Нийт дүн	2	19,773.5	2	19,773.5	

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,244.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 32,244.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Тайлант оны элэгдлийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"- 3.2-3.10, 3.17, 3.18 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 20,643.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 20,643.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоохоор алдаа, зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэхээр алдаа, зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 20,643.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.8 дахь заалт, мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөвлөлтийг бодитой төлөвлөн өр төлбөр үүсгэхгүй байх;

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.8 сая төгрөг, зарлагын 33.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах шийдвэр, гэрээ зэргийг тухай бүр шилэн дансны цахим мэдээллийн системд мэдээлээгүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.8 дахь заалт, мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг журмын дагуу үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Загруулсан		Загруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны элэгдлийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн	1	32244.1	0	-		32,244.10	1	32,244.10	0	0		
Дүн	1.00	32,244.10	-	-	-	32,244.10	1.00	32,244.10	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийлжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ер төлбөр үүссэн	1	20,643.00			0	-	1	20,643.00				
Дүн	1	20,643.00	0	-	-	-	1	20,643.00	0	0	0	0


Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.8 сая төгрөг, зарлагын 33.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах шийдвэр, гэрээ зэргийг тухай бүр шилэн дансны цахим мэдээллийн системд мэдээлээгүй	1	0							1	0
Дүн	1	0							1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА 2024.03.14

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Х.БОЛДБААТАР 2024.03.14

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР  Г.БААСАНЖАРГАЛ 2024.03.14